



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.05.12 № 01/271  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МӨНХӨӨНИЙ  
БАТБАЯР ТАНАА

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

#### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

#### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050” болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сонгуулийн хороонд  
Хавсралт ..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

З.ДАВААДОРЖ

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд Хөвсгөл аймгийн  
Тосонцэнгэл сумын “МУХАР ХӨНДИЙ” багт бие даан нэр  
дэвшигч МӨНХӨӨ-гийн БАТБАЯР миний мөрийн хөтөлбөр**

Мөнхөө овогтой Батбаяр миний бие 1970.11.05-нд төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 1986 оноос хойш ХАА-н салбарт ажиллаж байна.

- Сум орны хөгжлийн бодлогод иргэдийн санаа бодлыг тусган, олонхийн зарчмыг хүндэтгэн ажиллана.
- “Тосонцэнгэлд үйлдвэрлэв” бүтээгдэхүүнийг сурталчилан таниулахад хувь нэмрээ оруулж, үндэсний үйлдвэрлэл болон баялаг бүтээгчдээ дэмжиж ажиллана.
- Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй 20 мянган хурга төслийг хэрэгжүүлэгч төрийн бус байгууллагатай хамтарч ажиллаж, малчдын орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна.
- ИТХ-ын Хуралдаанаар баталсан тогтоол шийдвэрийг багийн Иргэдийн нийтийн Хуралдаанаар тогтмол мэдээлэн ажиллана.
- Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор, ОНХС-гийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлж ажиллана.
- Сумын 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэгт орж, сумынхаа хөгжилд хувь нэмрээ оруулна.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр байгуулагддаг, тухайн нутгийн иргэдийн хууль ёсны нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөх, тухайн нутаг дэвсгэрийн амьдралын асуудлыг тэдний эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж, эрхлэн хөтлөх үүрэг бүхий, үйл ажиллагаа нь Төлөөллийн Ардчилалын зарчим дээр үндэслэсэн, хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байгууллага билээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал юм.

Нутгийн өөрөө удирдах ёсны жинхэнэ эзэн бол баг, хорооны нутаг дэвсгэрт оршин суугаа нийт иргэн юм. Тэд нийтийн эрүүл мэнд, боловсрол, соёл, орчны ариун цэвэр, дэг журам, амгалан тайван амьдрах, нутаг, ус, бэлчээр, байгалийн баялгаа хэрхэн зөв зохистой ашиглах, өдөр тутмын үйлчилгээгээ хэрхэн зохион байгуулахаа хамтаараа хэлэлцэж, хамтын шийдвэр гаргаж ажиллана.

Шийдвэр гаргах нь иргэдийн шууд ба төлөөлөх оролцооны  
дээд хэлбэр юм.



3.88y B. Mmmmm